

**УИХ-ЫН 2014 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНООС ЗОХИОН
БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН**

2014.07.01

Улсын Их Хурлын 2014 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Эдийн засгийн байнгын хорооноос зохион байгуулсан ажлын дийлэнх нь улс орны нийгэм, эдийн засийн хөгжлийг тогтвортой хадгалах, макро эдийн засгийн тэнцвэртэй, тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлох, “Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх, уул уурхайн салбарын үйл ажиллагааг эрчимжүүлэхэд чиглэгдсэн зарим шаардлагатай хууль, бусад шийдвэрийг хэлэлцэн батлуулах, зарим хууль, тогтоомжийн хэрэгжилтийн явц байдлын талаар холбогдох байгууллага, яамдын мэдээлэл сонсож, үүрэг чиглэл өгөх, тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд багтдаг байгууллагуудын 2013 оны тайлан болон эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, холбогдох төсвийн захирагчдын 2013 оны төсвийн гүйцэтгэлийг хянан хэлэлцэх зэрэгт чиглэгдлээ.

Ээлжит чуулганы хугацаанд тус Байнгын хороо нийтдээ **20** удаа, хуулийн төслийн болон хяналтын чиглэлээрх ажлын хэсгүүд **60** гаруй удаа тус тус хуралдав.

НЭГ. ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

2014 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Эдийн засгийн байнгын хороо давхардсан тоогоор **50** гаруй асуудал хэлэлцэж, тэдгээр асуудлаар нийтдээ **30** орчим санал, дүгнэлт, танилцуулга бэлтгэн гаргаж, Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсний зэрэгцээ хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы хэлэлцүүлэгт бэлтгэх чиглэлээр **16** ажлын хэсгийг байгуулан ажилууллаа.

Чуулганы хугацаанд тус Байнгын хороогоор хэлэлцэгдсэн **22** хууль, **10** тогтоолыг эцэслэн батлаж, Олон улсын **1** гэрээ, хэлэлцээрийн төслийг зөвшилцэж, Чөлөөт бүсийн тухай, Зөвшөөрлийн тухай хуулийн төслүүд, тэдгээрийг дагалдсан

нийт **70** гаруй хууль, тогтоолын төслийн хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт шилжүүллээ. Ээлжит чуулганы хугацаанд батлагдсан нийт **22** хуулийн нэгээс бусад нь нэмэлт, өөрчлөлт оруулсан болон хүчингүй болгосон хуулиуд байгаа болно.

Макро эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хангаж, гадаад валютын ханшийн хэт өсөлтөөс сэргийлж, төсөв, мөнгөний бодлогыг уялдуулж, төсвийн зардлыг илүү хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах бодлогын хүрээнд “**Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай**” Улсын Их Хурлын тогтоолыг хэлэлцэн баталлаа. Уг тогтоолоор гадаад валютын урсгалыг сайжруулах, санхүү, эдийн засгийг эрсдэлээс сэргийлэх, бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах; эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийг дэмжих; хөгжлийн бодлого, хөгжлийн зээл, санхүүжилт; төрийн өмчийн удирдлагын тогтолцоог шинэчлэх” гэсэн үндсэн дөрвөн чиглэлийн 26 арга хэмжээг Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон холбогдох бусад байгууллагууд, хувийн хэвшилтэй хамтран авч хэрэгжүүлэхийг даалгалаа.

“**Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийг** баталж, эдийн засгийг дэмжих мөнгөний бодлогыг хэрэгжүүлж, инфляцийн түвшинг нэг оронтой тоонд байлгах, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг хоёр оронтой тоонд хадгалах, ажилгүйдлийн түвшинг 6,6 хувьд байлгах зэрэг зорилтуудыг дэвшүүлсэн нь эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалж, улмаар өсөлтийг хангах боломжийг бүрдүүлж байна.

Ээлжит чуулганы хугацаанд **Газрын тосны тухай хууль/шинэчилсэн найруулга/ батлагдан гарснаар газрын тос болон уламжлалт бус газрын тосны эрх зүйн орчин тодорхой болж, газрын тосны салбарт төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын эрх, үүрэг, газрын тосны нөөц ашигласны төлбөр, хураамжийн хувь хэмжээ, түүнийг ногдуулах, хөнгөлөх, чөлөөлөх болон тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, газрын тос эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой зохицуулалтуудыг боловсронгуй болголоо.** Монгол Улсад баригдах газрын тосны боловсруулах үйлдвэрийн түүхий эдийг дотоодоос хангах, улмаар газрын тосны бүтээгдэхүүний импортоос

хамааралтай байдлаас гарах, экспорт нэмэгдэх, гадаад валютын нөөц өсөх, ажлын байр нэмэгдэх зэрэг нийгэм, эдийн засгийн эөрөг үр дагаварыг бий болгож байна. Түүнчлэн бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах үед мөрдөгдөж байсан татварын нөхцөлийг хэвээр хадгалсан нь хөрөнгө оруулалтын эрх зүйн таатай орчинг бүрдүүлж байгаа юм.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсанаар олон улсын хөрөнгийн зах зээл дээрээс босгосон хөрөнгийн мэдээллийг холбогдох байгууллагаас авч мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нутгийн захиргааны байгууллагатай байгуулах гэрээ, ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн боловсруулалтын чанарыг сайжруулах, ашигт малтмалын баялаг, нөөцийн тухай нэр томьёог олон улсын жишгээр хуульчлах, Засгийн газар, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг; ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүргийг тодорхой болгож, хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг тодорхой хугацаанд хориглож байсан эрх зүйн зохицуулалтыг цуцаллаа.

Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар үйл ажиллагаа нь жигдэрсэн томоохон хязгаарлагдмал хариуцлагатай компаниуд хувьцаа болон түүнд хөрвөх үнэт цааснаас бусад аливаа хэлбэрийн үнэт цаас /өрийн бичиг болон бусад хуулиар зөвшөөрсөн санхүүгийн хэрэгсэл гэх мэт/-ыг хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд санал болгон гаргаж, хөрөнгийн зах зээл дээрээс урт хугацаатай, хөрөнгө оруулалтын хямд эх үүсвэр татах боломж бүрдэж байна. Түүнчлэн хувьцаат компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох болон хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон шинэ зохицуулалтуудыг хуульчиллаа.

Үүрэн телефон хэрэглэгч үйлчилгээ авч байгаа оператор компания өөрчлөх үед тухайн хэрэглэгчийн ашиглаж байгаа дугаарыг солихгүйгээр үргэлжлүүлэн ашиглуулах боломж олгох замаар хэрэглэгчдийн эрх аштийг хамгаалах, үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчдийн эрсөлдөөнийг идэвхжүүлэх чиглэлээр **Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулав.**

Ээлжит чуулганы хугацаанд Чөлөөт бүсийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, холбогдох бусад хуулийн төслүүд, Зөвшөөрлийн тухай хуулийн төсөл, холбогдох бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж, анхны хэлэлцүүлгийн шатанд шилжүүллээ.

Мөн Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгээс Засгийн газрын гишүүн, Эдийн засгийн хөгжлийн сайдыг огцруулах талаар гаргасан саналыг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж, огцруулах шаардлагагүй гэсэн санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд оруулаад байна.

Тайлант хугацаанд зээлийн хүү бууруулах асуудлыг судлан боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажилууллаа. Уг ажлын хэсэг "Зээлийн хүү буурах зах зээлийн орчныг бурдуулэхэд чиглэсэн 2014-2016 онд хэрэлжүүлах дунд хугацааны хөтөлбөр" боловсруулж, холбогдох яам, газруудаар хэлэлцүүлэн батлуулж, мөрдүүлэхээр Засгийн газарт хүргүүлээд байна.

Түүнчлэн тус Байнгын хорооноос өнгөрсөн онд байгуулагдсан ажлын хэсэг валютын ханшийг тогтвортжуулах, эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх асуудлаар УИХ-ын шийдвэрийн төсөл боловсруулж, Засгийн газарт хүргүүлснээр дээр дурдсан "Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай" тогтоолын төсөл өргөн мэдүүлэгдэж, батлагдсан болно.

Ээлжит чуулганы завсарлагааны хугацаанд тус хорооноос зохион байгуулахаар төлөвлөөд байгаа ажлын дийлэнж нь намрын зэлжит чуулганы хугацаанд хэлэлцэн батлуулах хууль, бусад шийдвэрийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх бэлтгэл ажлыг хангахад төвлөрч байгаа болно.

ХОЁРХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ТАЛААР

2014 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Байнгын хорооноос "Эрдэнэс-Таван толгой" ХК-ийн үйл ажиллагааг Үндэсний аудитын газартай хамтран шалгах үүрэг бүхий ажлын хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан шийдвэртэй

холбогдуулан иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдлын шийдвэрлэлтийн байдал, УИХ болон ЭЗБХ-оос тогтоол, хуралдааны тэмдэглэл, албан бичгээр өгсөн үүрэг чиглэлийн биелэлт болон Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиудын хэрэгжилтийг шалгах, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны үйл ажиллагааны талаар дүгнэлт гаргаж, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг тус тус байгуулан ажиллуулаад байна.

Ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурлаас байгуулагдаж түүнд ажлаа тайлagnadag Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хорооны 2013 оны үйл ажиллагааны тайланг Байнгын хорооны хуралдаанаар сонсож, тэдгээрийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч, үйл ажиллагааг нь цаашид эрчимжүүлэх чиглэлээр тодорхой үүрэг чиглэл, зөвлөмжүүдийг Байнгын хорооны тогтоолоор хүргүүллээ.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэлийн биелэлт, УИХ-ын 2013 оны 62 дугаар тогтоолын хэрэгжилт”-ийн талаарх Монголбанкнаас ирүүлсэн танилцуултыг Байнгын хороонд танилцаж байна.

Түүнчлэн тус байнгын хорооноос Уул, уурхайн сайдын “Эрдэнэс-Таван толгой” хувьцаат компанийн үйл ажиллагааны талаарх, Эдийн засгийн хөгжлийн сайдын “Засгийн газрын үнэт цасны арилжаагаар төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт, тэслийн сонголт, хэрэгжүүлэлт”-ийн талаар, Монгол Улсаас Японд суугаа элчин сайдын “Монгол-Японы эдийн засгийн хамтын ажиллагааны өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд”-ын талаарх мэдээллүүдийг тус тус сонслоо.

Улсын Их Хурлын 2011 оны 39 дугаар тогтоолын дагуу Үндэсний аудитын газар Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлтэд аудит хийж, тайлангаа УИХ-д ирүүлснийг Байнгын хороо сонсож, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны джгийн тухай хуулийн 46 джгаар зүйлийн 46.6-д “... Үндсэн чиглэлийн биелэлтийн тухай тогтоол батлана” гэж заасны дагуу Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлттэй холбогдуулж, Улсын Их Хурлаас гаргах тогтоолын төслийг боловсруулж, нэгдсэн

хуралдаанд танилцуулав. Улсын Их Хурлаас дээрх тогтоолыг гаргах шаардлагагүй гэж үзсэн болно.

Мөн тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд багтдаг Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2013 оны төсвийн гүйцэтгэлийн талаар санал, дүгнэлт гаргаж, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд жүргүүллээ.

Хаврын ээлжит чуулганы завсарлагааны хугацаанд тус Байнгын хорооноос зарим хууль тогтоомжийн хэрэгжилтийг холбогдох яам, газар, орон нутагт шалган танилцахаар төлөвлөж байна.

ГУРАВ. ЗОХИОН БАЙГУУЛСАН БУСАД АЖЛЫН ТАЛААР

Хотыг дахин хөгжүүлэх тухай хуулийн төслийг хэрэлцүүлэгт бэлтгэхтэй холбогдуулан Япон улсын “Жайка” ОУБ-ын хот төлөвлөлтийн асуудлаар мэргэшсэн зөвлөхүүдийг оролцуулсан “Хотыг дахин хөгжүүлэх тухай” сэдэвт уулзалт, ярилцлагыг зохион байгуулав.

Мөн Байнгын хорооны гишүүдийн Монголбанкны Эрдэнэсийн сангийн үйл ажиллагаатай танилцах үйл ажиллагааг зохион байгуулав.

Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоол төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хүрээнд “Их тэнгэр” цогцолборт 2 өдрийн хэлэлцүүлэг болон батлагдан гарсантай холбогдуулан хэвлэлийн бага хурал зохион байгууллаа.

ДӨРӨВ. БАЙНГЫН ХОРООНЫ ДОТООД АЖЛЫН ТАЛААР

Хаврын ээлжит чуулганы хугацаанд Тус Байнгын хороонд хандаж Төрийн болон бусад байгууллага, хуулийн этгээд, иргэдээс нийт 120 албан бичиг, 2 өргөдөл гомдол ирүүлснийг тухай бүрт нь шийдвэрлэн, хариуг холбогдох байгууллага, иргэдэд хургууллээ.

Мөн хугацаанд Байнгын хорооноос **16** тогтоол гаргасны зэрэгцээ Засгийн газар, яам, газар, байгууллагад нийт **84** хуудас бүхий **20** албан бичиг, нэг тогтоол, **3** хуралдааны тэмдэглэл /протокол/ хүргүүлсэн байна.

Тайлант хугацаанд тус Байнгын хорооноос хууль, УИХ-ын шийдвэрийн төсөл болон бусад материалыг **200** гаруй удаа /дундажаар **36000** хуудас/ олшруулж тараав.

Ээлжит чуулганы хугацаанд батлагдсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн хувийн хэрэг **6** нэгж, хуралдааны протокол **3** нэгж, албан бичиг **4** нэгж, нийт **13** нэгжийг тус тус бүрдүүлж, архивт хүлээлгэн өгөөд байна.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО